



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
 ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠭᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
 ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠦᠭᠢᠨ  
 ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
 ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
 ЗАСАГ ДАРГЫН  
 ЗАХИРАМЖ**

᠒᠐᠒᠒ оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/09

Алтай хот


**Дэмжлэг үзүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 01 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь :

1. Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Сүхбаатар нь хүнд өвчний шалтгаанаар Улаанбаатар хотын “Мөнгөн гүүр” эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа тул ирүүлсэн өргөдлийн дагуу эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлж 10,000,000 (арван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Батзориг)-д зөвшөөрсүгэй.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР